

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ

20\_\_ оны \_\_-р сарын \_\_-ны өдөр

Дугаар: \_\_\_\_\_

хот \_\_\_\_\_

Энэхүү үйлчилгээний ерөнхий гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 445-450 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 11 дүгээр зүйл, “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн 3 дугаар бүлэг, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 2 дугаар бүлэг, Төрийн банкны бодлого, журам, үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөлийг тус тус үндэслэн,

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1 хаягт орших, 9016001018 дугаар улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 5341469 регистрийн дугаартай, Төрийн банк ХХК, түүнийг төлөөлж \_\_\_\_\_ салбар/ тооцооны төв /цаашид “Банк” гэх/,

Нөгөө талаас \_\_\_\_\_ регистрийн дугаартай \_\_\_\_\_ хаягт орших, эцэг/эхийн нэр \_\_\_\_\_ өөрийн нэр \_\_\_\_\_, Хамтран эзэмшигч \_\_\_\_\_ регистрийн дугаартай \_\_\_\_\_ хаягт орших, эцэг/эхийн нэр \_\_\_\_\_ өөрийн нэр \_\_\_\_\_ Нөгөө талаас \_\_\_\_\_ хаягт орших \_\_\_\_\_ Улсын бүртгэлийн дугаартай, \_\_\_\_\_ тоот регистрийн дугаар бүхий \_\_\_\_\_ ХХК (цаашид “Харилцагч” гэх), хамтад нь “Талууд” гэх) нар Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авахаар дор дурдсан нөхцөлийг хүлээн зөвшөөрч, харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр Банк Харилцагчийн хүсэлтийг үндэслэн тогтоосон журмын дагуу харилцах данс /цаашид “Данс” гэх/ нээж, бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хийх төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, Харилцагч өөрийн дансны үлдэгдлийг Банкны үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл /“цаашид ҮХШЕН” гэх/-д заасан хэмжээгээр тогтмол байлгах, төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээний хөлсийг Банканд төлөхтэй холбогдон үүсэх харилцаа болон Талуудын эрх үүрэг, хариуцлага, гэрээг цуцлах, дуусгавар болох үндэслэл зэргийг хуулийн хүрээнд зохицуулахад оршино. ҮХШЕН гэж Банкнаас нийтэд зарласан бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, шимтгэлийг ойлгоно.

1.2. Банкнаас Харилцагчид үзүүлэх мөнгөн хадгаламж, зээл, чек, аккредитив болон бусад төлбөр тооцоотой холбоотой харилцааг тусгайлсан гэрээгээр зохицуулна.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

2.1. Дансны дугаар: \_\_\_\_\_ Валют: Төгрөг , Ам.доллар , Бусад

2.2. Бүтээгдэхүүний нэр: \_\_\_\_\_

2.3. Дансанд заавал байлгах доод үлдэгдэл: \_\_\_\_\_

2.4. Гэрээг 20\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-ны өдрөөс эхлэн харилцах данс хаагдах өдрийг хүртэл хугацаагаар байгуулав. Дансны орлого, зарлагын аливаа гүйлгээнд хязгаарлалт байхгүй.

2.5. Харилцагч гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох ба тухайн үед мөрдөгдөж байгаа байгаа ҮХШЕН-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрсөн болно. Цаашид ҮХШЕН-д нэмэлт өөрчлөлтүүдтэй Банкны [www.statebank.mn](http://www.statebank.mn) цахим хуудсаар орж танилцаж байхаар тохиролцов.

2.6. Банкны цахим хуудсаараа дамжуулан ҮХШЕН-д нэмэлт өөрчлөлт орох бүр нийтэд мэдээлснээр харилцагчаас тухайн нэмэлт, өөрчлөлтийн талаар энэхүү гэрээнд заасан хугацаанд санал, хүсэлтээ ирүүлээгүй бол, ҮХШЕН-д орсон нэмэлт өөрчлөлтийг Талууд хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр харилцан тохиролцов.

### ГУРАВ. ХАРИЛЦАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

**3.1. Харилцагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:**

3.1.1. Банкны ҮХШЕН-тэй танилцсаны үндсэн дээр Гэрээ болон журамд заасны дагуу данс нээлгэх, төлбөр тооцооны үйлчилгээ авах,

3.1.2. ҮХШЕН-д орсон нэмэлт өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрөхгүй бол нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор Банканд хандан санал хүсэлтээ бичгээр гаргах,

3.1.3. Дансны гүйлгээ, үлдэгдлийг дансны хуулгатай тулган шалгах,

3.1.4. Банканд нэн даруй мэдэгдэж төлбөрийн гүйлгээ гүйцэтгэхээс өмнө төлбөрийн даалгавраа цуцлах,

3.1.5. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг тогтоосон журмын дагуу авах,

3.1.6. 18 нас хүрч, эрх зүйн бүрэн чадамжтай болсоноор Банкнд ирж өөрийн гарын үсгийн загварыг өгч уг дансыг зарцуулах эрхээ нээлгэх,

3.1.7. Данс хамтран эзэмшигч нь нөгөө данс эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тухайн данснаас орлого, зарлагын гүйлгээ хийх, гэрээг цуцлах, дансны тодорхойлолт, хуулга авах, дансан дах үлдэгдэлд битүүмж хийх болон Банкны бусад үйлчилгээг авах,

3.1.8. Банк гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах.

**3.2. Харилцагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**

3.2.1. Банкнаас үйлчилгээ авах бүртээ хүчин төгөлдөр баримт бичгээр үйлчлүүлэх, өөрийн болон хамтран эзэмшигчийн талаарх үнэн зөв мэдээлэл, баримтыг Банканд гаргаж өгөх, хаяг, утас, ажил, албан тушаал зэрэг мэдээлэл өөрчлөгдөхөд Банкны ажилтанд мэдэгдэж холбогдох өөрчлөлтийг хийлгэх,

3.2.2. Төлбөр тооцооны баримтыг үнэн зөв, бүрэн бүрдүүлэх, Банкны ажилтны шаардсан баримт мэдээллийг өгөх,

3.2.3. Дансанд заавал байлгах үлдэгдэлийг тогтмол байршуулах, үйлчилгээний хөлсийг төлөх,

3.2.4. Дансны дугаар болон холбогдох мэдээллийн нууцлалыг хамгаалах,

3.2.5. Банкны цахим хуудсанд нэвтэрч ҮХШЕН-ийн нэмэлт өөрчлөлттэй танилцах,

3.2.6. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу хүүний орлогоос татвар төлөх,

3.2.7. Дансаа гуравдагч этгээдэд дамжуулан ашиглуулахгүй, бусдын гүйлгээг шилжүүлэхгүй бөгөөд хууль бус үйлдлээс үүдэн гарах хохирлыг хариуцах,

3.2.8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Банкны ажилтны шаардсан аливаа баримт мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, бүрэн гаргаж өгөх, хууль, тогтоомжийг зөрчихгүй байх,

3.2.9. Банкны үйл ажиллагааны алдаанаас харилцагчийн дансанд илүү хүү бодогдсон, бусдын гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн тохиолдолд Харилцагч үл маргах журмаар эргүүлэн төлөх,

3.2.10. Данснаас 40 000.00 /дөчин сая/ төгрөг түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаас дээш дүнтэй мөнгө бэлнээр зарлагдах бол энэ тухайгаа ажлын 1 хоногийн өмнө Банканд мэдэгдэх.

### ДӨРӨВ. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

**4.1. Банк дараах эрхийг эдэлнэ. Үүнд:**

- 4.1.1. Хууль тогтоомжид заасны дагуу Харилцагчийн хувийн хэргийг бүрдүүлэх, шинэчлэх болон бусад үйлчилгээтэй холбогдуулан нэмэлт баримт, мэдээллийг шаардах, гаргуулан авах,
- 4.1.2. ҮХШЕН-д өөрийн санаачилгаар нэмэлт өөрчлөлт оруулах,
- 4.1.3. Банкны ҮХШЕН-д заасны дагуу үйлчилгээний шимтгэл, хураамжийг Харилцагчийн данснаас үл маргах журмаар суутгах, дансан дах үлдэгдэл нь шимтгэл, хураамжийг суутгахад хүрэхгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах,
- 4.1.4. Банкны үйл ажиллагааны алдаанаас харилцагчийн дансанд илүү хүү бодогдсон, гүйлгээ андуурч шилжүүлэгдсэн зэрэг тухайн харилцагчид хамааралгүй тохиолдолд Харилцагчийн данснаас тухайн мөнгөн дүнгээр, үл маргах журмаар эргүүлэн авах, залруулах,
- 4.1.5. Карт, хадгаламжийн дэвтрийг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан тухай Банканд мэдэгдээгүй, түүнчлэн бусад дамжуулснаас Харилцагчийн дансан дах мөнгөн хөрөнгө хууль бусаар ашиглагдсон тохиолдолд учирсан хохирлыг Банк хариуцахгүй,
- 4.1.6. Татварын хууль тогтоомжийн дагуу харилцагчийн дансанд бодогдсон хүүгийн орлого, түүнтэй адилтгах бусад татварын орлогод ногдуулах албан татварыг суутгаж Татварын байгууллагад шилжүүлэх,
- 4.1.7. Тодорхой гүйлгээг эрсдэлтэй, гэмт хэргийн шинжтэй, хууль бус гэж үзвэл гүйлгээг хийхээс татгалзах,
- 4.1.8. Хууль, журам, энэхүү Гэрээг зөрчсөн тохиолдолд харилцагчийн гүйлгээг түдгэлзүүлэх, Банкны санаачилгаар гэрээг цуцалж учирсан хохирлыг төлүүлэх, эрх бүхий байгууллагад мэдэгдэх зэрэг арга хэмжээг авах,
- 4.1.9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу гүйлгээний талаар мэдээллийг шаардах,
- 4.1.10. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу хоёрдмол зориулалтай бараа бүтээгдэхүүнтэй холбоотой гүйлгээ хийхгүй,
- 4.1.11. Харилцагч гэрээгээр хүлээсэн үүргээ болон бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэх заавар зөвлөмжийг зөрчсөн тохиолдолд Банк дараах үйлдлийг хийх эрхтэй. Үүнд
- 4.1.11.1. Харилцагчийн гүйлгээг хийх эрхийг түдгэлзүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг шаардах,
  - 4.1.11.2. Харилцагчийн гүйлгээ болон гүйлгээний дүнд тодорхой хязгаарлалтуудыг тогтоох,
  - 4.1.11.3. Харилцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол нэг талын санаачилгаар цуцалж, бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг цуцлах
- 4.2. Банк дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**
- 4.2.1. Харилцагчийн мэдээллийн нууцлалыг чандлан хадгалж, хууль, журам, гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусад задруулахгүй,
- 4.2.2. Харилцагчийн баримт мэдээлэл дутуу, Банкны ажилтны шаардсан мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан тохиолдолд аливаа үйлчилгээ үзүүлэхгүй,
- 4.2.3. Харилцагчийн даалгавраар бэлэн ба бэлэн бус хэлбэрээр гүйлгээг хийх,
- 4.2.4. Өөрийн буруутай үйлдлийн улмаас Харилцагчид учруулсан хохирлыг нотлогдсон хэмжээгээр хариуцан нөхөн төлөх,
- 4.2.5. Үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл, заавар зөвлөмжийг харилцагчид өгөх,
- 4.2.6. Харилцагчийн нэмэлт үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх,
- 4.2.7. Данс идэвхигүй төлөвт шилжсэн ба дансны үлдэгдэл ТЭГ /0/ болсон тохиолдолд дансыг хаах.

#### ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- 5.1. Дараах нөхцөлд Гэрээ дуусгавар болно. Үүнд:
- 5.1.1. Харилцагч дансаа хаалгах хүсэлт гаргасан,
  - 5.1.2. ҮХШЕН-д заасан дансны доод үлдэгдэлийг хангаагүй 12 сар болсон,
  - 5.1.3. Харилцагчийн бүрдүүлсэн баримт бичиг хуурамч болох нь тогтоогдсон,
  - 5.1.4. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хууль бус үйл ажиллагаанд ашигласан,
  - 5.1.5. Харилцагч өөрийн дансыг төлбөр тооцооны бус зориулалтаар удаа дараа /2 болон түүнээс дээш/ ашигласан /бусдын нэр дээр баталгаа батлан даалт гаргах, үйлчилгээ эрхлэх, дансыг ашиглан бусад хохирол учруулж болзошгүй буюу залилан луйврын шинжтэй үйлдэл гарах нөхцөлийг
  - 5.1.6. Хуульд заасан бусад үндэслэлээр.

#### ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Талууд Гэрээ болон хууль тогтоомж зөрчсөний улмаас учирсан хохирлыг хариуцна.
- 6.2. Харилцагчийн дансны үлдэгдэл хүрэлцээгүй, төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэр дутуу, буруу болон хүлээн авагч банкны үйлчилгээний доголдол зэргээс Харилцагчийн төлбөр саатсан бол үүссэн үр дагаврыг Банк хариуцахгүй.
- 6.3. Баримт бичгээ хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, нууц үгээ бусад задруулсан, дамжуулсан, ашиглуулсан зэрэг Харилцагчийн буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас өөрт болон бусад учирсан хохирлыг хариуцна.
- 6.4. Харилцагч төлбөр тооцооны баримтыг хуурамчаар үйлдэх, залилах, хууран мэхлэх, Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчих замаар Банкинд хохирол учруулсан тохиолдолд хохирлыг харилцагчийн данснаас үл маргах журмаар төлүүлнэ.

#### ДОЛОО. БУСАД

- 7.1. Энэхүү Гэрээг монгол хэл дээр үйлдэж гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 7.2. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Энэ гэрээний нөхцөлтэй танилцан харилцах данс нээхийг зөвшөөрсөн:

Харилцагч: Овог нэр, баталгаат гарын үсэг: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_  
Харилцагч: Овог нэр, баталгаат гарын үсэг: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Банкны ажилтны нэр, гарын үсэг, тамга тэмдэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_